#### ЦАХИМ ЕРТӨНЦ ДЭХЬ НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас өөрийн гишүүн улс орнуудад мэдээлэл, харилцаа холбооны салбарын шинэ технологи, ололт нэвтэрч буй энэхүү интернэтийн орчин дахь бага насны хүүхдийг төрөл бүрийн сөрөг нөлөөлөл ба мэдээллээс хамгаалах, мэдээллийн агуулгыг хүүхдүүдэд хэрэгтэй сургалт, танин мэдэхүйн чиглэлээр хөгжүүлэх, тусгайлсан сургалтанд хамруулах, мэдээлэл харилцаа холбооны мэдлэг, боломжийг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, бусад олон улсын байгууллага, улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулах, хяналт аюулгүй орчинг бүрдүүлэх зэрэг чиглэлээр ажиллахыг гишүүн улс орнуудтай хамтран ажилладаг байх. Тус байгууллагаас "Protecting Children in Cyberspace" санаачилга төслийг хэрэгжүүлж байгаа.

Интернет сүлжээгээр бага насны болон өсвөр насны хүүхдэд хор хөнөөлтэй, зохисгүй контент агуулсан мэдээлэл, цахим хуудас, видео тоглоом ихээр байршуулсан байдаг. Эдгээр зохисгүй мэдээллүүд рүү бага насны хүүхдүүд цахим хуудсын хаяг алдаж бичих, хайлтын системийн нэмэлт илэрцээс сонгох, насанд хүрэгчдэд зориулсан зар сурталчилгааны баннер дээр дарах зэрэг олон төрлийн арга замаар нэвтрэн ордог. Энэ нь насанд хүрээгүй хүүхдийг цахим хүчирхийлэлд өртөх, интернет сүлжээ ашиглаглан үйлдэгдэж буй гэмт хэргүүд /хүний наймаа, бэлгийн мөлжлөг/-ийн золиос болох, хүчирхийллийг ил тодоор харуулсан мэдээллээс болж сэтгэл зүйн өөрчлөлттэй болох, хүмүүжлийн доголдолтой болох зэрэг эрсдлийг дагуулдаг.

#### Иймд цахим хуудасны хөтөч дээр шүүлтүүр программ суулгах

Цахим хөтөч бүр бага насны хүүхдийг интернет орчноос хамгаалах тохиргоотой байдаг ч хөтөч нэг бүр дээр хийх шаардлага гардаг. "OpenDNS" программыг ашиглан цахим хуудасны хандалтыг хязгаарлах боломжтой. Энэ программ хангамжийг гэр бүлийн хэрэгцээнд зориулан ашиглахад үнэ төлбөргүй бөгөөд таны router төхөөрөмж болон компьютер дээр тодорхой хандалтыг хязгаарлах чадалтай.

**5-7 насны хүүхдүүд:** Энэ насны хүүхдүүдийн ихэнхи нь технологитой харьцаж сурах үе. Эцэг эх, насанд хүрсэн хүн тогтмол хянаж байх шаардлагатай. Шүүлтүүрийн программуудыг хэрэглэх, аюулгүй сайтуудын жагсаалтыг гаргах нь зүйтэй.

**8-12 насны хүүхдүүд:** Тэд интернэтийн талаар анхны ойлголт туршлагатай болсон үе. Энэхүү насныхан ойлгож сонирхсон маш олон асуудлууд байдаг бөгөөд

1

түүндээ хариу авах сонирхолдоо хөтлөгдөн одоо байгаа хязгаараасаа давж болзошгүй. Шүүлтүүрийн программ болон өөр бусад дагалдах техник хэрэгслийг хэрэглэх нь ашигтай.

**13 ба түүнээс дээш насныхан:** Энэ насны бүлгийнхэн технологийн дэвшлийг мэргэшсэн түвшинд хүртэл сайн эзэмшиж хэн нэгний хараа хяналтгүйгээр ашигладаг залуу үеийнхэн юм. Шүүлтүүрийн программууд нь чухал ач холбогдолтой.

К9<sup>1</sup> нь гэрийн хэрэглээнд зориулагдан бүтээгдсэн, үнэгүй веб шүүлтүүрийн программ хангамж юм. Та гэрийн компьютераа бүх төрлийн онлайн халдлагаас хамгаалах, насанд хүрэгчдийн, бооцоот тоглоомын гэх мэт вэб хуудас руу хандалтыг хязгаарлахын тулд мэдээллийн сан нь байнга шинэчлэгддэг, хамгаалалтын найдвартай шийдэл хэрэгтэй.

Blue Coat Systems компаниас гаргасан К9 веб шүүлтүүрийг ашигласнаар та гэрийнхээ компьютерийн интернэт орчинг бүрэн хянах боломжтой болох юм. Уг программ хангамж нь дараах боломжуудыг өөртөө агуулдаг.

## К9 Веб Шүүлтүүрийн Боломжууд:

- Веб сайтуудыг насанд хүрэгчдийн, бооцоот тоглоомын, тагнуулын программ хангамжийн, чаатын холбогдолтой гэх мэт 70 орчим ангилалд хувааж хандалтыг хязгаарлах
- Google, Yahoo, Ask гэх мэтийн түгээмэл хайлтын системүүдэд аюулгүй хайлт боломжийг нэмэх
- Тодорхойлсон веб сайтууд руу хандах цагийн хязгаарлалт тавьж өгөх
- Өөрөө веб сайтуудын жагсаалт үүсгэж, тэдгээр рүү хандах, хаах эрхийг тавих
- Веб хуудас руу хандах хандалтыг нууц үгээр түгжих
- Веб орчны үйл ажиллагааг хянах, тайлан үзэх
- Шинээр бий болсон хортой цахим хуудсуудыг автоматаар ангилж оруулах
- Windows болон Мас үйлдлийн системүүд дээр суулгах боломжтой.

### Ашиглах заавар

- http://www1.k9webprotection.com/get-k9-web-protection-free холбоосоор орж К9 программ хангамжийн лицензийг авна. Лиценз нь үнэ төлбөргүй байх бөгөөд та зөвхөн өөрийн овог нэр, мэйл хаягийг бөглөснөөр таны имэйлд хэдхэн секундын дараа лиценз ирсэн байх болно.
  - Get K9 Free for your home гэсэн сонголтыг идэвхижүүлнэ

<sup>&</sup>lt;sup>1</sup> http://www1.k9webprotection.com/

- First name гэсэн хэсэгт өөрийн нэрээ бичнэ

- Last name гэсэн хэсэгт овог-оо бичнэ

- Email гэсэн хэсэгт и-мэйл хаягаа бичнэ. Энэ хаягаар лиценз ирэх учраас үнэн зөв бөглөх шаардлагатай

- Verify Email өмнө оруулсан мэйл хаягаа дахин оруулна

- How did you hear about us энэ хэсэгт та K9 веб шүүлтүүрийн талаар хаанаас олж мэдсэн тухайгаа сонголтуудаас сонгоно. Энэ талбарыг заавал бөглөх шаардлагагүй.

- Эцэст нь **Request License** товч дээр дарж баталгаажуулснаар таны мэйл хаяг руу лиценз очно.

( K9 We	eb Protection		10
0	from Blae@Coat	B YOME THE M	Autori, 1.5. September 21.5 sector
	NOTE GROOM S	enter associa anteresta a	RORPES ADDREEDING COAT
Bar	Get K9 Web I	Protection	
1 Ann	As part of the Blue Coat Connuct Increases. You not easy purchase privationed, non-polity of other of	p Chimant Program, 40 Vini Protection is free for a borrow to use ED Uni Protection for bostness, 10	2
	How to Get K9 Web Prot	ection:	C
Gel Hill annual	<ol> <li>You will need a lownar step. 20 pea, You altookt replace it is in</li> </ol>	ngg, Northe same inter and cell moderness. Ng Tan Tot model	Download K9 today
	2. Policie the instructions in the e email and pales 1 that the Red	8	
	KB Web Protection Licer	tee Request (* required fields)	5.2
	<ul> <li>Get KD Free for your turn</li> </ul>	<ul> <li>C) Get KS for your organization.</li> </ul>	Servad the overel
	Paulturas*		0.0
And a result	Lattitiene"		225
	Ermit stryt		Ш 🛄
	NETE To prevent analythertax address that only pional and	d unive from bypassing Kb, yes as inheri ess.	Tell a friend.
	Verity Ernal *		
	How did you have anout we'll		
		Report Litette	
	(Please role (lut your 52 literate the to protect environment of a comparing to the comparing to the comparing to the comparing to the comparing the test of the test of the comparing the test of test of the test of tes	a good? for user on only one consistent of you would also, preservation additional License Requests by date cam and closing on "Set Ab Issue")	

2. Таны мэйл хаягт дараах и-мэйл ирсэн байх бөгөөд улаанаар тэмдэглэсэн хэсэгт лиценз код агуулагдана.



1. Татаж авсан програмаа суулгана. Суулгах явцад гарч ирэх асуултын талбаруудыг дараах байдлаар бөглөнө.

- K9 user license – Мэйлээр ирсэн лиценз кодоо оруулна.

- K9 Administrator Password - Программ руу нэвтрэхэд ашиглах нууц үгээ бөглөнө.

- Verify Password – Нууц үгээ дахин оруулна.

- Install товчыг дарж суулгана.

User License & Password			
Enter a user license and administrator pr	assword		1
Please enter your K9 User License and A License please dick the 'Request a Licen	kdministrator Passwor se " link.	d. If you do not have	a K9 User
Ucense			
K9 User License:	E.		
	4	Request a License	
Create Administrator Password			
K9 Administrator Password	1		
Verify Password:			
This password is required to configure a	nd change K9 setting	Enter a password the	et children
will not be able to easily guess (for exam addresses, and so on).	sple, avoid family birth	idays, phone numbers	÷
durify Install Social of the American			

Жич : Та программд нэвтэрч веб сайтуудыг хаах, нээх зэрэг үйлдэл хийхэд дээр бөглөсөн нууц үгээрээ нэвтрэх тул тааж олж болох амархан нууц үг (утасны дугаар, нэр, регистрийн дугаар гэх мэт) хийхгүй байх, мөн бусдад нууц үгээ алдахгүй байх хэрэгтэй.

2. Компьютераа дахин ачааллуулах сонголт гарч ирнэ.

- Reboot now – Яг одоо дахин ачааллуулна.

- I want to manually reboot later – Энэ сонголтыг сонгосон бол програмыг алдаагүй ажиллуулахын тулд компьютераа заавал гараар дахин ачааллуулах шаардлагатай.



1. Программ хангамжаа суулгаж дууссан бол Start цэснээс Blue Coat K9 Web Protection Admin руу орно. Програм нь веб интерфэйст суурилж ажилладаг тул Google Chrome, Mozilla Firefox, IE гэх мэт веб хөтчөөр http://127.0.0.1:2372 гэсэн хаяг руу хандан орно.

Жич : **Google Chrome** веб броузер ашиглан орвол ямар нэг алдаагүй ажиллах болно.

- Гарч ирэх дэлгэцнээс Setup цэс рүү орж веб шүүлтүүрийн дэлгэрэнгүй боломжуудыг тохируулна. Setup цэс дээр дарахад гарч ирэх нууц үг асууж буй цонхонд 5 дахь алхам дээр хийсэн нууц үгээ бөглөнө.
- Веб шүүлтүүрийн үндсэн дэлгэц дараах байдлаар харагдах бөгөөд категори, url буюу хаягаар, цагийн хязгаарлалтаар гэх мэтчилэн веб сайтуудыг хязгаарлах боломжтой.



- Web Categories to block Веб сайтуудыг насанд хүрэгчдийн, мөрийтэй тоглоомын гэх мэт категориудад ангилсан байх бөгөөд та өөрт тохируулан хүссэн байдлаараа категориудыг хаах нээх боломжтой
- Time Restrictions Цагийн хязгаарлалт үүсгэж тухайн цагууддаа веб сайтуудыг нээж, хаах боломжтой.
- Web Site Exceptions Категорид багтаагүй веб сайтыг жагсаалтад нэмэх, категорид байгаа вебийн хандах эрхийг нээх боломжтой.
- Blocking effects Хандах эрхийг нь хаасан веб сайт руу нэвтрэх үед үзүүлэх хариу үйлдэл тодорхойлно. Тухайлбал, хориглосон сайт руу хандах үед нохой хуцах дуу гаргах гэх мэт.
- Url Keywords Тодорхойлсон үг орсон бүх веб сайтыг хаана. Тухайлбал, chat гэсэн үг орсон бүх сайтуудыг хаах гэх мэт.
- Safe search Google, Yahoo гэх мэт түгээмэл хэрэглэгддэг хайлтын системүүдийн илэрцүүдийг шүүж харуулна.

- Other Settings HTTPS ачааллыг шүүлтүүрээр шүүх, youtube сайтаас насанд хүрэгчдийн холбогдолтой бичлэг, сэтгэгдлүүдийг хаах гэх мэт боломжтой.
- Password/Email Нууц үг болон имэйл хаягаа программд шинэчлэн бүртгүүлэх боломжтой.
- К9 update Шинээр нэмэгдсэн сайтуудыг хянаж байхын тулд та програмаа байнга шинэчлэж байх хэрэгтэй.

## Шүүлтүүрийн программыг ашиглах нь:

1. Өөрийн сонгосон категориудыг хаах. Тухайлбал, торрент татах сайтыг хаахгүй гэж үзвэл та Web Categories to Block -> Custom сонгож орон Peer-to-Peer сонголтыг идэвхигүй болгож хадгалах товч дарснаар Торрент сайтууд руу хандах боломжтой болно.

![](_page_5_Picture_5.jpeg)

 Цагийн хязгаарлалттайгаар веб сайтуудыг хаах. Та өдрийн бүх цагт, зөвхөн шөнө, дурын гэсэн 3 сонголтоор тодорхойлсон веб сайтуудыг хаах боломжтой.
 Хэрэв сайтуудыг хаах цагаа өөрөө тодорхойлох бол Time Restrictions Custom цэс рүү орж 7 хоног, 24 цагийн сонголтоос сонгож веб сайтуудыг хаах болон нээх боломжтой.

	The second	And all shall be as a set of the	an Annu and	and the life		and ideas		
	Others and manual		a and we	494 (D. 148		and stands		
111th Categorius Is Block	CONTRACTOR AND THE ADDRESS AND THE ADDRESS AND ADDRESS							
Tarm Restrictions	· Castori	And they be			Induced Villet and			
The read was been added	Class to called a class line shot in the and house.							
S Photos States	Color W. Seren	of case i						_
D receipt stacts	22.00.000	- Barr	Max	-	Tree	- Per	Per	liet
UNE Regresorits	1.00	-						_
C. Sals Search	345							_
of Other Settings	2.08	-	1					
a contraction of the second se	8.00							
Personal Fundament	8.00	-	1					
Rit Lipdate	8.00	_	-					
	1:00							1.1
	8.08							
	8:08							
	10.05							1
	10.00							
	42-85 PM				_		_	Ariga Pett
	1:08							Bob Pat A
	805	_		_		_	_	Server
	8.09							-
	8.08		-		_		_	-
	5.09	_	_		_			
	6.00		-		_			-
	7.00	_		_				-
	8.00	-		_	_	_		_
	10.00		_		_			
	10.00						-	-

3. Тодорхойлсон үг орсон бүх веб сайтуудыг хаах. URL keywords цэс рүү орж Keyword to Add хэсэгт хориглох үгээ бичнэ. Тухайлбал poker гэх мэт. Жич : Монголоор бичиж болохгүй.

C IDME	🐫 NEW HITEHET ACTIVITY 💥 BETTHE	(
2	URL Keywords	
<u> </u>		
SETUP	Create a list of keywords to block. Mana Madp	
Theb Categories to Block	URL Reported to sense difference of the URL Causes a 80 Minute page to chapter	
Toma Realistana	Keyword to Add:	
Web file Exceptions.	2066/	
Blocking Effects	G ANY INCOM	
193. Keywords	Q SAU	
Salo Scarch	O stratter	
Celter Satenge	Hide Keywards man in the second or 42 Black segme	

4. Дурын веб сайтыг хаахын тулд **Web Site Exceptions** -> **Always Block** руу орж хаах веб сайтынхаа нэрийг бичиж өгнө. **Always Allow** хэсэгт хаагдсан веб сайтыг бичиж нээж болно.

A none	NEW INTERNET ACTIVITY X LIGT	IP GETHELP		
	Web Site Exceptions	dwaya alizo. Mare Help		
Web-Categories to Stock	Wengen Ricck, (these regardless of sengers) Then Sile to AAR [answ-Istalhand core] Q Add to Line Q southing care)	Aways Allow Asses reperties at Lengery Web Star to Add Enter a LPL In orthogical Bases Ho orthogical Star Star		
Citier Search Other Settings Processor(Ctreat	C DecINAL WEIved Passimine - Anno acting instant fra which door not enter making the action passion health for actionstrations:			

Дээрх тохиолдолд насанд хүрээгүй хүүхдүүд нь өөрсдийгээ яаж аюулгүй байлгах вэ гэдгийг ойлгуулах шаардлагатай:

- ✓ Хууль бус болон аюултай контенттэй санамсаргүй тааралдвал юуг анхаарах
- Айлгасан мэдээллийг дамжуулах үед юу хийх
- ✓ Өөрийн хувийн мэдээллийг сайн хамгаалах
- ✓ Зохиогчийн эрх түүнтэй холбоотой асуудлыг хүндэтгэх
- ✓ Онлайн орчинд сургалт, худалдааны үйл ажиллагаанд оролцоход юуг анхаарах зэрэг болно.

# Т.ТУЯА /МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХУУЛЬ ЗҮЙН МАГИСТР, ЦАГДААГИЙН ХОШУУЧ/